



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

64101 Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Номгон баг  
Вэбсайт: www.bayankhongor.gov.mn  
Утас: 7044-5018, Факс: 7044-3206

2020.01.21 № 19/67

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Санал хүргүүлэх тухай

Г ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН Т  
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

Таны 2020 оны 01/74 дугаар албан бичгээр ирүүлсэн “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар төсөл”-тэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

1.Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны Хүснэгт 8.6-ийн 2-т тусгагдсан Шивээхүрэн-Арвайхээр 451 км автозамын төслийг өөрчилж Шивээхүрэн-Гурвантэс–Баянлиг-Богд-Өлзийт /Баянхонгор аймгийн/-Арвайхээр байхаар тусгаж өгөх.

2.Баянлиг сумд олон улсын нисэх онгоцны буудал барих.

3.Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах.

4.Аялал жуулчлалын чиглэлээр соёлын их, дээд сургууль байгуулах саналтай байна.

ДАРГА



Г.БАТЖАРГАЛ

1191540

## БАЯНХОНГОР – САНАЛ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018.05.04-ны өдрийн 08 дугаар “Журам жагсаалт, төлбөрийн хэмжээ батлах тухай” тогтоолын 2-р хавсралтаар ЭМ-ийн даатгалын сангаас дараах тусламж үйлчилгээнд зардлын төлбөрийг хариуцах тухай заасан.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээний багц:

### 1. Сэргээн засах тусламж үйлчилгээний багцанд тусгасан эмчилгээ:

- Үений далайц сайжруулах дасгал
- Биеийн тэнцвэр сайжруулах дасгал
- Булчингийн хүч сайжруулах дасгал
- Утах эмчилгээ /утлага/
- Гэрлийн эмчилгээ зэргийг хийх боломжтой

### 2. Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ

- Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээг хүнд, удаан хугацаанд хэвтэрт байгаа өвчтөн хөгжлийн бэрхшээлтэй
- Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээнд сувилахуйн болон сэргээн засах тусламж орно
- Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд ЭМС-ын 2017 оны А/40 тоот “Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ыг мөрдлөг болгож ажилладаг.

3. Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх Сувилахуйн төв нь өдрийн эмчилгээ, сувилгааны багцуудад заасан ажлуудыг хийж гүйцэтгэдэг. Иймд уг тогтоолд Сувилахуйн дагнасан үйлчилгээ үзүүлэх байгууллага, төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээний багцийг санхүүжүүлэхээр тусгавал сувилахуйн тусламж үйлчилгээг иргэдэд бодитой хүргэх, тусламж үйлчилгээнд чанарын ахиц гарах, тусламж үйлчилгээ үзүүлэгч сувилагч нарын нийгмийн асуудлыг шийдэхэд чухал байна. Мөн сувилахуйн бие даасан тусламж үйлчилгээг хөгжүүлэх, сувилагч нарыг мэргэжлээрээ чадваржих, шийдвэр гаргах, хөгжиж, ОУ-ын түвшинд ойртсон төвүүдийг бий болгоход суурь дэмжлэг болно.